



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ХУВЬЦААТ КОМПАНИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 10 сарын 04 өдөр

Деталь 8/250.

Хөртөн сүм

Хөдөлмөрийн гэрээ дуусгавар болгож өөр ажилд шилжүүлэх, томилох,
цалинжуулах, ажил хүлээлцүүлэх комисс томилох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 37.1.1, 24.1 дэх заалтууд, Монгол улсын Авлигатай тэмцэх газрын 2016 оны 9 дүгээр сарын 29 ны өдрийн 01/6681 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалтыг үндэслэн Чалхаагийн Одбаярыг Цахилгаан шугам сүлжээний цехийн даргын албан тушаалаас 2016 оны 9 дүгээр сарын 23 ны өдрөөс чөлөөлж хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгосугай.

2.Ажлын шаардлагыг үндэслэн Ч.Одбаярыг Дорнод салбарын даргын албан тушаалд 2016 оны 9 дүгээр сарын 23 ны өдрөөс эхлэн томилон ажиллуулсугай.

3.Авлигатай тэмцэх газрын 2016 оны 9 дүгээр сарын 29 ны 01/6681 тоот албан бичгийн дагуу Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн Ч.Одбаярыг Дорнод салбарын даргаар томилон ажиллуулахад ашиг сонирхлын зөрчил үүсэх нь тогтоогдоогүй тул дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж, мөн хуульд заасан хориглолт хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахыг даалгасугай.

4.Ч.Одбаяр, Г.Отгонбаатар нарын ажил хүлээлцэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Комиссын дарга: Н.Баасанпүрэв / Дотоод хяналтын албаны дарга/
Гишүүд: М.Сэнгэдорж- /ИА-ны ахлах инженер/
Г.Ганбүргэд- /Үндсэн хөрөнгийн ня-бо/
О.Нармандах - /ЗУХ-ийн ХХХ-ийн мэргэжилтэн/

5.Ч.Одбаярыг Захирлын зөвлөлийн гишүүнээр ажиллуулсугай.

6.Ч.Одбаярыг холбогдох бүлгийн цалингаар цалинжуулахыг Төлөвлөлт, Санхүү бүртгэлийн хэлтэс (У.Энхчимэг)-т зөвшөөрсүгэй. ✓

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.ОТГОНБААТАР

